



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 05 дугаар сарын 25
№ 21 /930/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1470

Монгол Улсын
хууль

1513

Монгол Улсын
Их Хурлын
тогтоол

1530

Эмнэлгийн тусламж,
үйлчилгээний тухай

Эрүүгийн хуулийг дагаж
мөрдөх журмын тухай

Хөдөө аж ахуйн “Халх гол”
үндэсний бүтээн байгуулалтын
бүс байгуулах тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

477.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай	1470
478.	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1491
479.	Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1492
480.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1492
481.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1493
482.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1512
483.	Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1513
484.	Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1514
485.	Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1518
486.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1519
487.	Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай	1520
488.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1520
489.	Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1521

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

490.	Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай	Дугаар 42	1521
491.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 43	1528



492.	“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 44	1529
493.	“Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 45	1529
494.	Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай	Дугаар 46	1530
495.	Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 47	1531
496.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай	Дугаар 49	1531
497.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай	Дугаар 50	1532
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
498.	Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 35	1532
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ			
2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр		Улаанбаатар хот	
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ			
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ			
1 дүгээр зүйл.Хуулийн зорилт			
1.1.Энэ хуулийн зорилт нь хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах, удирдах, санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.			



2 дугаар зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль тогтоомж

2.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Эрүүл мэндийн тухай хууль², Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль³, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль⁴, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“эмнэлгийн тусламж, үйлчилгээ” гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг;

3.1.2.“эмнэлэг” гэж эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

3.1.3.“өрхийн эмч” гэж өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллах өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн хүний их эмчийг;

3.1.4.“эрүүл мэндийн даатгал” гэж Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3.1.1-д заасныг;

3.1.5.“эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ” гэж эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний илгээсэн үйлчлүүлэгчид энэ хуулийн 8.1-д заасан байгууллагаас үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг;

3.1.6.“хяналт тавих” гэж эрх бүхий байгууллагаас эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн холбогдох хууль тогтоомж,

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Эрүүл мэндийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

³ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 8 дугаарт нийтлэгдсэн.



заавал мөрдөх стандарт, дүрэм, журам, удирдамж, зааврыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих, шалгах, үнэлэх, зөвлөн туслах цогц арга хэмжээг;

3.1.7.“нэг иргэнээр тооцсон төлбөрийн арга” гэж өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын санхүүжилтийг өрхийн эмчид бүртгүүлсэн иргэнээр тооцохыг;

3.1.8.“тохиолдолд суурилсан төлбөрийн арга” гэж эмнэлгийн тусламж, үйлчилгээний тохиолдол бүрээр зардлыг тооцож санхүүжүүлэхийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4 дүгээр зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл

4.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ дараахь төрөлтэй байна:

4.1.1.өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтний анхан шатны тусламж, үйлчилгээг бие дааж, эсхүл багаар үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

4.1.2.өрхийн анагаах ухаанаас бусад мэргэшлийн эмнэлгийн мэргэжилтний бие дааж, эсхүл багаар үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ;

4.1.3.жирэмсэн, төрөлт, төрсний дараахь үед эх, ураг, нярайд эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх эх барихын тусламж, үйлчилгээ;

4.1.4.хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж;

4.1.5.гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;

4.1.6.өвчин эмгэг бүхий үйлчлүүлэгчийг асран сувилах замаар эрүүл мэндийг дэмжих, хөнгөвчлөх, илааршуулахад чиглэсэн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;

4.1.7.өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий

болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ.

5 дугаар зүйл.Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

5.1.Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, хянах, эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах үйл ажиллагааг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ хамаарна.

5.2.Энэ хуулийн 14.2.1-д заасан тусгай зөвшөөрөл бүхий өрхийн эрүүл мэндийн төв нь аймгийн төв, нийслэлд, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь сум, тосгонд өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

5.3.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн байршил, үйлчлэх хүрээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлтийн хүрээнд тухайн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

5.4.Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.5.Энэ хуулийн 5.4-т заасан журам, бусад үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хэрэгжүүлнэ.

6 дугаар зүйл.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн чиг үүрэг

6.1.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2, 16.7-д заасан үндсэн чиг үүргээс гадна дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.энэ хуулийн 6.2-т заасан жагсаалт дахь тусламж, үйлчилгээг үзүүлэх;

6.1.2.эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;



6.1.3.харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

6.1.4.энэ хуулийн 6.2-т заасан жагсаалтын сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх;

6.1.5.сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх.

6.2.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7 дугаар зүйл.Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийг сонгон бүртгүүлэх, лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ авах

7.1.Монгол Улсын иргэн өөрийн оршин суугаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл бүхий өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийг сонгон үйлчлүүлнэ.

7.2.Орон нутгийн иргэн ойр байгаа нутаг дэвсгэрийн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийг сонгон үйлчлүүлж болно.

7.3.Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэхтэй холбогдох харилцааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

7.4.Иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүний эрүүл мэндтэй холбоотой асуудлаар өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчид хандах бөгөөд эмчийн заавар, чиглэлээр эрүүл мэндийн холбогдох бусад байгууллагад хандана.

7.5.Иргэн дараахь тохиолдолд эмнэлгийн лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг болон хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвд шууд хандаж болно:

7.5.1.осол, гэмтэлд өртсөн, амь тэнссэн, эмнэлгийн яаралтай тусламж авах хойшлуулшгүй нөхцөл байдал үүссэн;

7.5.2.төрөх үеийн эх барихын яаралтай тусламж, үйлчилгээ авах;



7.5.3.шүд, эрүү, нүүр амны өвчин эмгэгийн улмаас тусламж, үйлчилгээ авах.

7.6.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэнийг эмнэлгийн лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт илгээхтэй холбогдох харилцааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

8 дугаар зүйл.Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

8.1.Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг энэ хуулийн 14.2.2-т заасан тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, амаржих газар, клиник үзүүлнэ.

8.2.Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ энэ хуулийн 3.1.5-д заасан тусламж, үйлчилгээнд хамаарна.

8.3.Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.4.Клиник нь эмнэлгийн мэргэшсэн болон эх барихын тусламж, үйлчилгээ, яаралтай тусламжийг үзүүлэх, сургалт, судалгаа, үндсэн үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ эрхэлнэ.

8.5.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, амаржих газар нь эмнэлгийн мэргэшсэн болон эх барихын тусламж, үйлчилгээ, түргэн тусламжийн үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлэх, эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэрэглэх, хадгалах, донорын зориулалтаар эд, эрхтэн бэлтгэх, хэрэглэх, хадгалах, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, эмнэлгийн үндсэн үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ явуулна.

9 дүгээр зүйл.Эх барихын тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

9.1.Эх барихын тусламж, үйлчилгээг тусгай зөвшөөрөл бүхий өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, клиник, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг үзүүлнэ.

9.2.Эх барихын лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амаржих газар, нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг үзүүлнэ.



9.3.Эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлэх өрхийн эрүүл мэндийн төв, клиникээс бусад байгууллага эхийн амрах байртай байна.

9.4.Эх барихын тусламж, үйлчилгээнд мөрдөх заавар, үр хөндөх, жирэмслэлтийг таслах ажилбар гүйцэтгэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10 дугаар зүйл.Эмнэлгийн яаралтай тусламжийн зохион байгуулалт

10.1.Эмнэлгийн яаралтай тусламжийг тусгай зөвшөөрөл бүхий өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, клиник, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг үзүүлэх бөгөөд өрхийн эрүүл мэндийн төвөөс бусад байгууллага яаралтай тусламжийн нэгжтэй байна.

10.2.Эмнэлгийн болон төрөх үеийн яаралтай тусламжийг тухайн иргэнд ойр байгаа эрүүл мэндийн байгууллага үзүүлнэ.

10.3.Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үйлчлүүлэгчийг эрэмбэлэх болон яаралтай тусламжийг зохион байгуулахтай холбогдох заавар, журам, маягтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11 дүгээр зүйл.Түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалт

11.1.Түргэн тусламжийн үйлчилгээг тусгай зөвшөөрөл бүхий түргэн тусламжийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, өмчийн бүх хэлбэрийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг үзүүлнэ.

11.2.Түргэн тусламжийн үйлчилгээг яаралтай тусламжийн чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн болон тухайн чиглэлээр сургагдсан эрүүл мэндийн бусад ажилтнаас бүрдсэн баг үзүүлнэ.

11.3.Түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалт, үйлчлэх хүрээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

12 дугаар зүйл.Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

12.1.Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээг дараахь хэлбэрээр үзүүлнэ:

12.1.1.эмнэлгийн бусад тусламж, үйлчилгээтэй хамт цогц байдлаар;

12.1.2.дагнасан байдлаар.

12.2.Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээг тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд үзүүлнэ.

12.3.Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага дараахь төрөлтэй байна.

12.3.1.сувилахуйн төв;

12.3.2.хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв.

12.4.Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон эмнэлгээс илгээсэн үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

12.5.Сувилахуйн болон хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвийг байгуулах журам, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа, сувилгааны төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.6.Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар зохицуулна.

13 дугаар зүйл.Сэргээн засах тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

13.1.Сэргээн засах тусламж, үйлчилгээг дараахь хэлбэрээр үзүүлнэ:

13.1.1.эмнэлгийн бусад тусламж, үйлчилгээтэй хамт цогц байдлаар;

13.1.2.дагнасан байдлаар.

13.2.Сэргээн засах дагнасан тусламж, үйлчилгээг тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд үзүүлнэ.

13.3.Сэргээн засах дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага дараахь төрөлтэй байна:



- 13.3.1.сэргээн засах төв;
- 13.3.2.сувилал.

13.4.Сэргээн засах тусламж, үйлчилгээг сэргээн засахын эмч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч, сэтгэл засалч болон сэргээн засахын бусад мэргэжлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн үзүүлнэ.

13.5.Сэргээн засах төв, сувилал байгуулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам болон сувилал, сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.6.Сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар зохицуулна.

14 дүгээр зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тусгай зөвшөөрөл

14.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй байна.

14.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 19.3.1-д заасан тусгай зөвшөөрлийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад дараахь төрлөөр олгоно:

- 14.2.1.өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;
- 14.2.2.эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ;
- 14.2.3.эх барихын тусламж, үйлчилгээ;
- 14.2.4.эмнэлгийн яаралтай тусламж;
- 14.2.5.түргэн тусламжийн үйлчилгээ;
- 14.2.6.сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;
- 14.2.7.сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан төрлөөр эмнэлгийн тусламж, үйлчилгээний болон техник, технологийн хэрэгцээний тодорхойлолт авах, мэргэжлийн үйл ажиллагааны төсөл боловсруулж хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хянах, бүртгэх, мэдээлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулна.

14.4.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл болон хүний нөөцөд тавих шаардлагыг



эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага стандартын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран батална.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ЭМНЭЛГИЙН
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**15 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг
сонгох, түүнд тавих шаардлага**

15.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараахь шалгуурыг хангасан байна:

15.1.1.тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй;

15.1.2.нийгмийн эрүүл мэнд болон анагаах ухааны боловсролтой, эсхүл эрх зүй, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр мэргэшсэн, эрүүл мэндийн салбарт ажилласан туршлагатай байх;

15.1.3.улс төрийн намын удирдах, орон тооны болон сонгуульт ажил эрхэлдэггүй;

15.1.4.бусад эрүүл мэндийн байгууллагад хөрөнгө оруулалт хийгээгүй.

15.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа зургаан жил байна.

15.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах зорилгоор анхны гишүүнээс дөрвийг буюу өмчлөгчийн төлөөллөөс бусад төлөөллийн тус бүр хоёр гишүүнийг гурван жилээр, бусад таван гишүүнийг зургаан жилээр сонгож, цаашид энэ хуулийн 15.2-т заасан хугацааг баримтлан баталгаажуулна.

15.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны гишүүний өмчлөгчийн төлөөллөөс бусад төлөөллийн гишүүний энэ хуулийн 15.3-д заасан хугацааг сугалаагаар шийдвэрлэнэ.

15.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор нэг удаад удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр хүртэлх тооны гишүүнийг нөхөн сонгоно.

15.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүнээс нэр дэвшүүлэн нууц санал хураалтаар олонхийн саналаар сонгоно.

15.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.



15.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нас барсан, түүнийг энэ хуулийн 15.10-т зааснаар эгүүлэн татсан бол насаар хамгийн ахмад гишүүн шинэ даргыг сонгох хүртэл үүргийг нь гүйцэтгэнэ.

15.9.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын түр эзгүйд түүний санал болгосон гишүүн, хэрэв санал болгоогүй тохиолдолд насаар хамгийн ахмад гишүүн орлоно.

15.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараахь үндэслэлээр эгүүлэн татна:

15.10.1.эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;

15.10.2.гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон;

15.10.3.энэ хуулийн 15.1-д заасныг зөрчсөн нь сонгогдсоны дараа тогтоогдсон;

15.10.4.өөр ажилд шилжих болсон, улс төрийн намын удирдах, орон тооны болон сонгуульт албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон;

15.10.5.өмчлөгчийг төлөөлөх гишүүний албан тушаал өөрчлөгдсөн;

15.10.6.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд дараалан гурав ба түүнээс дээш удаа биечлэн оролцоогүй.

15.11.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

15.11.1.энэ хуулийн 15.21-д заасан урамшууллаас гадна албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас шууд буюу шууд бусаар бэлэг, үйлчилгээ, мөнгөн орлого, зээл, тусламж авах, хөнгөлөлт эдлэх;

15.11.2.тухайн төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нэгдмэл сонирхолтой этгээдийг санал болгох, захиалгын нийлүүлэгчээс ашиг авах;

15.11.3.гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох.



15.12.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг энэ хуулийн 15.10, 15.11-д зааснаас бусад үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө эгүүлэн татах болон чөлөөлөхийг хориглоно.

15.13.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, нас барсан, эсхүл энэ хуулийн 15.10, 15.11-д заасан үндэслэлээр эгүүлэн татсан, чөлөөлсөн тохиолдолд энэ хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшүүлсэн болон сонгон шалгаруулсан хүнийг эрх бүхий этгээд нэг сарын дотор баталгаажуулна.

15.14.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, түүний шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина.

15.15.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа, шаардлагатай гэж үзвэл ээлжит бус хуралдааныг удирдах зөвлөлийн дарга, эсхүл таваас доошгүй гишүүний санал болгосноор хуралдуулна.

15.16.Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

15.17.Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

15.18.Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн, санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал, санал хураалтын дүн, гаргасан шийдвэрийн тухай тэмдэглэл хөтөлж, шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд удирдах зөвлөлийн дарга хуралдааны тэмдэглэл, тогтоолд гарын үсэг зурж баталгаажуулна.

15.19.Төлөөлөн удирдах зөвлөл тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

15.20.Төлөөлөн удирдах зөвлөл орон тооны нэг ажилтантай байна.

15.21.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшуулал, зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг эмнэлгийн төсвөөс санхүүжүүлнэ.

15.22.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын жишиг хэмжээ, олгох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.



15.23.Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар нээлттэй сонгон шалгаруулна.

15.24.Энэ хуулийн 15.23-д заасан нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хурал доор дурдсан төлөөллийг оролцуулан тус тусдаа хуралдана:

15.24.1.даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагын төлөөллийг сонгох;

15.24.2.эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг сонгох;

15.24.3.эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөллийг сонгох.

15.25.Энэ хуулийн 15.23-д заасан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах байгууллага нэр дэвшүүлэн сонгох хурлын товыг 14 хоногийн өмнө олон нийтэд нээлттэй зарлана.

15.26.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөлөлд нэр дэвшүүлэх төрийн бус байгууллага дараахь шаардлагыг хангасан байна:

15.26.1.сүүлийн зургаан сараас дээш хугацаанд тасралтгүй үйл ажиллагаа явуулсан;

15.26.2.тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй;

15.26.3.санхүүгийн зөрчилгүй.

15.27.Нэр дэвшүүлэн сонгох хуралд энэ хуулийн 15.23-т заасан сонгон шалгаруулалтын дагуу даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллага, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөл өөрсдийн эрх барих байгууллагын баталгаажуулсан нэг хүнийг нэг эмнэлгийн сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлж, хуралд тухайн байгууллагын төлөөлөл нэг санал өгөх эрхтэйгээр оролцоно.

15.28.Эмнэлэг тус бүрийн нэр дэвшүүлэн сонгох хуралд энэ хуулийн 15.1-д заасан шалгуурыг хангасан нэр дэвшигчийг танилцуулж,



илээр санал хураан олонхийн санал авсан нэг нэр дэвшигчийг, эсхүл нэр дэвшигчийн аль нь ч олонхийн саналыг аваагүй бол санал тэнцсэн буюу хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг хоёр дахь санал хураалтад оруулж, олонхийн санал авсан нэр дэвшигчийг энэ хуулийн 15.30-д заасан эрх бүхий этгээдэд хурлын тэргүүлэгчдийн гарын үсэг бүхий хурлын тэмдэглэлийг баталгаажуулан хүргүүлнэ.

15.29.Нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.30.Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг аймаг, дүүргийн Засаг дарга шууд батламжилна.

16 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн гүйцэтгэх удирдлага, эрх, үүрэг

16.1.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн гүйцэтгэх удирдлагыг тухайн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгон шалгаруулж томилсон эмнэлгийн захирал хэрэгжүүлнэ.

16.2.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.3.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирал дараахь шаардлагыг хангасан байна:

16.3.1.эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан;

16.3.2.эрүүл мэндийн байгууллагад таваас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан;

16.3.3.нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэн;

16.3.4.тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрх нь шүүхийн шийдвэрээр хасагдаагүй;

16.3.5.улс төрийн намын гишүүн бус;



16.3.6.хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлдэггүй;

16.3.7.бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд хавсран ажилладаггүй.

16.4.Эмнэлгийн захирлыг төлөөлөн удирдах зөвлөл таван жилийн хугацаагаар томилох бөгөөд дахин нэг удаа улируулан томилж болно.

16.5.Энэ хуулийн 16.7.1-д заасан гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, эмнэлгийн захирал гарын үсэг зурах бөгөөд гэрээнд энэ хуульд зааснаас бусад эрх, үүрэг, хүлээх хариуцлага, цалин хөлс, урамшуулал, холбогдох бусад асуудлыг тусгасан байна.

16.6.Эмнэлгийн захирал дараахь нийтлэг эрхтэй байна:

16.6.1.эмнэлгийн дэд захирал болон зохион байгуулалтын нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулж, томилох;

16.6.2.удирдлагын багийн гишүүн, байгууллагын ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах;

16.6.3.төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хуваарийн дагуу эмнэлгийн төсвийг захиран зарцуулах;

16.6.4.батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулж, хэмнэсэн зардлыг тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах үйл ажиллагаанд зарцуулах;

16.6.5.төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах зэргээр эмнэлгийг төлөөлж үйл ажиллагаа явуулах;

16.6.6.энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан эрх.

16.7.Эмнэлгийн захирал дараахь нийтлэг үүрэгтэй байна:

16.7.1.төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулан ажиллах;

16.7.2.эмнэлгийн гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх;

16.7.3.хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулах;



16.7.4. тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг төлөөлөн удирдах зөвлөлд гаргаж өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүр төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх;

16.7.5. энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан үүрэг.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
САНХҮҮЖИЛТ**

**17 дугаар зүйл. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн
төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилт**

17.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6-д заасан тусламж, үйлчилгээний зардлыг улсын төсвөөс дараахь аргаар санхүүжүүлнэ:

17.1.1. энэ хуулийн 6.2-т заасан тусламж, үйлчилгээний жагсаалтыг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар;

17.1.2. нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа, арга хэмжээний зардлыг эдийн засгийн ангиллаар;

17.1.3. түргэн тусламжийн үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

17.1.4. жирэмсэн, төрөлт, төрсний дараахь үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

17.1.5. эмнэлгийн яаралтай тусламжийн зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

17.1.6. гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эдийн засгийн ангиллаар;

17.1.7. аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврах явцад гэмтсэн, өвчилсөн иргэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар.

17.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан тусламж, үйлчилгээний



зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

17.3.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв энэ хууль болон Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаас бусад тохиолдолд иргэнээс төлбөр авч тусламж, үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

18 дугаар зүйл.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн болон тусгай эмнэлэг, амаржих газар, клиникийн үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилт

18.1.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн болон тусгай эмнэлэг, амаржих газар, клиникийн үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6-д заасны дагуу улсын төсвөөс дараахь аргаар санхүүжүүлнэ:

18.1.1.жирэмсэн, төрөлт, төрсний дараахь үеийн эх барихын тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

18.1.2.халдвар судлалын үйлчилгээ, заавал болон тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалт, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэлийн зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

18.1.3.гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн тусламж, үйлчилгээний болон нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа, арга хэмжээний зардлыг эдийн засгийн ангиллаар;

18.1.4.хүүхдэд үзүүлэх эмнэлгийн зарим тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

18.1.5.хорт хавдар, сэтгэцийн эмгэг, халдварт өвчний зарим тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

18.1.6.түргэн тусламжийн үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

18.1.7.эмнэлгийн яаралтай тусламжийн зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

18.1.8.аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврах явцад гэмтсэн, өвчилсөн иргэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;



18.1.9. удаан хугацааны нөхөн сэргээх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар;

18.1.10. бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар.

18.2. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн болон тусгай эмнэлэг, амаржих газар, клиникийн үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасны дагуу тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

19 дүгээр зүйл. Сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, сэргээн засах төв, сувиллын үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилт

19.1. Сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, сэргээн засах төв, сувиллын үзүүлэх сувилахуйн болон сэргээн засах дагнасан тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

20 дугаар зүйл. Түргэн тусламжийн байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилт

20.1. Түргэн тусламжийн байгууллагын үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар улсын төсвөөс санхүүжүүлнэ.

21 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зохицуулалт

21.1. Энэ хуулийн 17.1, 17.2, 18.1, 18.2, 19.1, 20.1-д заасан тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээг тогтооход тухайн тусламж, үйлчилгээний удирдамж, стандартад суурилсан норматив өртгийн тооцоонд үндэслэсэн жишгийг мөрдөнө.

21.2. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн болон тусгай эмнэлэг, амаржих газар, клиник нь энэ хуулийн 18.1, 18.2-т заасан тусламж, үйлчилгээг гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэх бөгөөд санхүүжилт авах журам, гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.



21.3.Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.

21.4.Энэ хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлж болох бөгөөд нэмэлт үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэхтэй холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

21.5.Төрийн болон орон нутгийн өмчит эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон энэ хуулийн 21.4-т заасан нэмэлт тусламж, үйлчилгээний төлбөрийг үйлчлүүлэгч өөрөө хариуцна.

21.6.Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх энэ хуулийн 18.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сонгон шалгаруулах болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Засгийн газар батална.

21.7.Энэ хуулийн 21.6-д заасан үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дангаар болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран хэрэгжүүлнэ.

21.8.Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх энэ хуулийн 18.1-д заасан тусламж, үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ЭМЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

22 дугаар зүйл.Мэргэшсэн болон резидент эмчийн эрх, үүрэг

22.1.Мэргэшсэн эмч нь Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эмнэлгийн мэргэжилтний эрх, үүргээс гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:



22.1.1.үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх, зөвлөгөө өгөх, эмчилгээ, мэс засал, ажилбар хийх;

22.1.2.эмийн жор бичих;

22.1.3.нас барсныг тогтоох;

22.1.4.хүйсийг тогтоох;

22.1.5.цэргийн алба хаах, тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах, хуульд заасан зарим албан тушаалд томилогдох болон бусад нөхцөлд иргэний эрүүл мэндийн талаар тодорхойлолт гаргах;

22.1.6.шүүх, прокурорын байгууллагын шийдвэрээр эмчийн үзлэг хийх, шинжилгээ авах, эмчилгээ хийх, дүгнэлт гаргах, иргэний эрх зүйн чадамжийг үнэлэх;

22.1.7.өөрийнх нь шууд хяналт, удирдлагад ажиллах резидент эмчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

22.1.8.оношлох, эмчлэх зорилгоор үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх ажлыг резидент эмчээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд резидент эмчид зөвшөөрөл олгосон шийдвэрийг бичгээр үйлдэж, удирдах албан тушаалтанд мэдэгдэх;

22.1.9.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

22.2.Резидент эмч нь Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эмнэлгийн мэргэжилтний эрх, үүргээс гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

22.2.1.энэ хуулийн 22.2.2, 22.2.3-т заасан ажлыг гүйцэтгэхдээ мэргэшсэн эмчээс арга зүйн туслалцаа авах;

22.2.2.эмнэлгийн удирдах албан тушаалтны баталсан резидент эмчийн бие даан үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтын дагуу үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх;

22.2.3.мэргэшсэн эмчийн шууд хяналт, удирдлага доор үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, мэс засал, ажилбарыг хийх;

22.2.4.энэ хуулийн 22.2.2-т заасан ажлыг гүйцэтгэх явцад аливаа хүндрэл гарсан тохиолдолд мэргэшсэн эмчид цаг алдалгүй мэдэгдэх;

22.2.5.хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.



22.3.Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.4.Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, төгсөлтийн дараахь сургалт, мэргэшлийн зэрэгтэй холбоотой харилцааг Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

23 дугаар зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээг магадлан итгэмжлэх

23.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллага тусламж, үйлчилгээний төрөл, технологи, чанар, гүйцэтгэлийг үнэлүүлж, сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлэл авна.

23.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэхтэй холбоотой харилцааг Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

24 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

24.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, улсын байцаагч, шүүгч зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд дараахь шийтгэл оногдуулна:

24.1.1.энэ хуулийн 22.1.7, 22.1.8, 22.1.9, 22.2.2, 22.2.3, 22.2.4, 22.2.5-д заасныг зөрчсөн бол мэргэшсэн эмч, резидент эмчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

24.1.2.энэ хуулийн 8.4, 8.5, 9.4, 10.2-т заасныг зөрчсөн бол эмч, эмнэлгийн мэргэжилтэн, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;



24.1.3.энэ хууль болон Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгцээний тодорхойлолт болон тусгай зөвшөөрөлгүй этгээд эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулсан бол иргэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

24.2.Эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн бол эрх бүхий байгууллага, улсын байцаагч тухайн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагааг хоёр сар хүртэл хугацаагаар зогсоох, энэ хугацаанд зөрчлөө арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, эсхүл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг “Сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн мэргэшлээр лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, удирдлагатай холбоотой харилцааг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.” гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэг:

“7.9.Энэ хуулийн 7.7 дахь хэсэг төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагчид хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг.”

2/14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хяналт, эмнэлгийн үйлчилгээнд тавих шаардлага, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.”



2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “хуульд заасан бусад” гэсний дараа “төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн” гэж, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Төрийн байгууллага, албан газар” гэсний дараа “, төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг” гэж, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засаг дарга” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.20-3.1.23 дахь заалт:

“3.1.20.“эмнэлгийн бусад мэргэжилтэн” гэж анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардагдахгүй бусад мэргэжилтнийг;

3.1.21.“сэргээн засах” гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах болон эмнэлгийн бусад мэргэжилтний хамтын цогц үйл ажиллагааг;

3.1.22.“үндсэн мэргэшил” гэж анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн их эмчийн анагаахын шинжлэх ухааны нэг салбарын чиглэлээр дагнан ажиллах мэдлэг, чадвар, дадлыг;

3.1.23.“төрөлжсөн мэргэшил” гэж анагаах ухааны боловсрол олгох сургууль төгссөн эмнэлгийн мэргэжилтний анагаахын шинжлэх ухааны нэг салбарын нарийвчилсан төрлөөр ажиллах мэдлэг, чадвар, дадлыг.”



2/13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг:

“13.7.Хүн амыг олноор хамарсан халдварт өвчний дэгдэлт болон аюулт үзэгдлийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгахад чиглэсэн эрүүл мэндийн байгууллагын дангаар болон төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран үзүүлэх гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17.1.2-т заасан эрүүл мэндийн алба мөн хуулийн 18.1.1-д заасны дагуу зохион байгуулна.”

3/15 дугаар зүйлийн 15.1.13, 15.1.14 дэх заалт:

“15.1.13.төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг;
15.1.14.сувилахуйн төв.”

4/16 дугаар зүйлийн 16.16, 16.17 дахь хэсэг:

“16.16.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь төрөлжсөн мэргэшлээр улсын хэмжээнд эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэн эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий байгууллага байна.

16.17.Сувилахуйн төв нь байнгын асаргаа сувилгаа шаардах ахмад настан, архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.”

5/17 дугаар зүйлийн 17.8-17.11 дэх хэсэг:

“17.8.Төрийн өмчит эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15.1-д заасан шалгуурыг хангасан гишүүнийг дараахь байдлаар нэр дэвшүүлнэ:

17.8.1.эмнэлгийн өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүнийг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус бүр нэг хүнийг нэр дэвшүүлснээр;

17.8.2.эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүнийг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн болон эмнэлгийн мэргэжилтнээс бусад ажилтны төлөөлөл тус бүрээс нэг хүнийг тухайн хамт олны ердийн олонхийн төлөөлөл оролцсон ирцтэй хурлаас нэр дэвшүүлснээр;

17.8.3.олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан

байгууллага, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл тус бүр нэг хүнийг сонгон шалгаруулснаар.

17.9.Орон нутгийн өмчит эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15.1-д заасан шалгуурыг хангасан гишүүнийг дараахь байдлаар нэр дэвшүүлнэ:

17.9.1.эмнэлгийн өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүнийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан нэгжээс тус бүр нэг хүнийг нэр дэвшүүлснээр;

17.9.2.эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүнийг энэ хуулийн 17.8.2-т заасны дагуу тухайн хамт олны ердийн олонхийн төлөөлөл оролцсон ирцтэй хурлаас нэр дэвшүүлснээр;

17.9.3.олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг энэ хуулийн 17.8.3-т заасны дагуу сонгон шалгаруулснаар.

17.10.Төлөөлөн удирдах зөвлөл дараахь эрхтэй байна:

17.10.1.эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, төлөвлөгөөтэй нийцүүлж эмнэлгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөг батлах;

17.10.2.эрүүл мэндийн салбарын бодлого, төлөвлөгөөтэй нийцүүлж эмнэлгийн хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг батлах;

17.10.3.эмнэлгийн тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, төсвийн хуваарилалтыг батлах;

17.10.4.төсвийн хязгаарт нийцүүлэн эмнэлгийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоох;

17.10.5.эмнэлгийн захирлыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх;

17.10.6.эмнэлгийн дэд захирал болон зохион байгуулалтын нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулах журмыг батлах;

17.10.7.эмнэлгийн тухайн жилийн болон дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах;



17.10.8.эмнэлэгт хэрэгжүүлэх концессын болон бусад төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

17.10.9.эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд үнэлэлт, дүгнэлт гаргах;

17.10.10.эмнэлгийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

17.10.11.эмнэлгийн захиралтай байгуулсан гэрээг дүгнэх;

17.10.12.эмнэлгийн санхүүгийн, төсвийн гүйцэтгэлийн болон аудитын тайланг хэлэлцэх;

17.10.13.аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламжийн зарцуулалтыг хэлэлцэж, хэрэгжилтэд хяналт тавих;

17.10.14.шаардлагатай гэж үзвэл эмнэлгийн үйл ажиллагаа, гүйцэтгэлд мэргэжлийн байгууллага, шинжээчээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэх;

17.10.15.хуульд заасан бусад бүрэн эрх.

17.11.Төлөөлөн удирдах зөвлөл дараахь үүрэгтэй байна:

17.11.1.байгууллагын хөгжлийн болон хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

17.11.2.эмнэлгийн тухайн жилийн болон дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хяналт тавих;

17.11.3.эмнэлгийн тухайн жилийн төсвийн зарцуулалтад хяналт тавих;

17.11.4.эмнэлгийн захирлыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, чөлөөлж чадаагүй тохиолдолд татан буугдах;

17.11.5.эмнэлэгт хэрэгжүүлэх концессын болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн хэрэгжилтэд хяналт тавих;

17.11.6.эмнэлгийн захирлын гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэх;



17.11.7.эмнэлгийн захирлын хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эмнэлэгт учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх;

17.11.8.төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод тайлагнах;

17.11.9.хуульд заасан бусад үүрэг.”

6/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:

“19.3.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь чиглэлээр олгоно:

19.3.1.эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх;

19.3.2.эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх;

19.3.3.мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бодис, угтвар бодис болон эм үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх;

19.3.4.биологийн идэвхит бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх;

19.3.5.эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм худалдах;

19.3.6.эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх;

19.3.7.ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх;

19.3.8.ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх.”

7/19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг:

“19.5.Тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллага нь энэ хуулийн 19.4-т заасан тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас хэрэгцээний тодорхойлолт авна:

19.5.1.эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа шинээр эрхлэх;



19.5.2.өндөр өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах, өндөр өртгөөр засварлах;

19.5.3.эрүүл мэндийн байгууллагын одоогийн хүчин чадлыг 30 ба түүнээс дээш хувиар нэмэгдүүлэх;

19.5.4.эрүүл мэндийн байгууллагын зориулалтын барилга байгууламж барих, өргөтгөх, зориулалтаар өөрчлөн засварлах.”

8/19 дүгээр зүйлийн 19.8, 19.9 дэх хэсэг:

“19.8.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 120 хоногийн дотор энэ хуулийн 19.7-д заасан байгууллагаас гаргасан дүгнэлтийг үндэслэн хэрэгцээний тодорхойлолтыг олгоно.

19.9.Тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллага хэрэгцээний тодорхойлолтыг үндэслэн барилгын зураг төсвийг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулна.”

9/19 дүгээр зүйлийн 19.12 дахь хэсэг:

“19.12.Энэ хуулийн 19.11-т заасан шинжээчийн баг өргөдлийг дараахь байдлаар хянан үзнэ:

19.12.1.хүсэлт гаргагчийн бүрдүүлсэн баримт бичгийг нягтлан магадлах;

19.12.2.тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллагын барилгын гүйцэтгэлд энэ хуулийн 19.10.4-т заасан холбогдох байгууллагын гаргасан шийдвэрийг судлах;

19.12.3.энэ хуулийн 19.10.3-т заасан мэргэжлийн үйл ажиллагааны төслийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж үнэлэх;

19.12.4.тусгай зөвшөөрөл олгох эсэх дүгнэлтийг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.”

10/19 дүгээр зүйлийн 19.14, 19.15 дахь хэсэг:

“19.14.Тусгай зөвшөөрлийг дараахь тохиолдолд олгохгүй:

19.14.1.энэ хуулийн 19.10-т заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй;



19.14.2.энэ хуулийн 19.10-т заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;

19.14.3.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаагүй;

19.14.4.энэ хуулийн 19.10.4-т заасан байгууллагын шийдвэр гараагүй;

19.14.5.тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллага татан буугдсан;

19.14.6.хүсэлт гаргагчийн эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь энэ хууль, бусад хууль тогтоомжийн дагуу цуцлагдсан болон энэ хуулийн 19.14.2-т заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохгүй тухай шийдвэр гарсан, түүнээс хойш нэг жилийн хугацаа өнгөрөөгүй.

19.15.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тухай шийдвэрийг 10 хоногийн дотор хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.”

11/19 дүгээр зүйлийн 19.18, 19.19 дэх хэсэг:

“19.18.Тусгай зөвшөөрлийг тухайн байгууллагад анх удаа олгож байгаа бол гурав, сунгаж байгаа бол таван жилийн хугацаагаар олгоно.

19.19.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг сунгасан, эсхүл сунгахаас татгалзсан тухай шийдвэрээ хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргана.”

12/19 дүгээр зүйлийн 19.20.3-19.20.8 дахь заалт:

“19.20.3.эрүүл мэндийн байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгүүлээгүй;

19.20.4.эрүүл мэндийн байгууллагын барилга, тоног төхөөрөмж нь үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлагыг хангахгүй байгаа тухай эрх бүхий байгууллага дүгнэсэн;

19.20.5.мэргэжлийн хүний нөөц бүрдээгүйгээс тусгай зөвшөөрөлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжгүй;



19.20.6.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын эрсдэл үүссэн гэж эрх бүхий байгууллагаас дүгнэсэн;

19.20.7.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны чиглэл, төрлөөс өөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн;

19.20.8.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.”

13/19 дүгээр зүйлийн 19.22-19.29 дэх хэсэг:

“19.22.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр нь үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зарим чиглэл, төрөлд хамаарах бол тухайн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг хэсэгчлэн хүчингүй болгоно.

19.23.Энэ хуулийн 19.20.3, 19.20.4, 19.20.5, 19.20.6, 19.20.7-д заасан нөхцөл байдал бүрэн арилсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг сэргээн олгоно.

19.24.Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 19.2-т заасан эрх бүхий байгууллагаас хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн тухай шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагад шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор мэдэгдэж, уг шийдвэрийг олон нийтэд нээлттэй болгоно.

19.25.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.3-т зааснаас гадна дараахь чиглэлээр хяналт тавина:

19.25.1.үйл ажиллагааны стандарт, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангахад чиглэсэн энэ хуулийн 19.10.3-т заасан төслийн хэрэгжилтийг хянах, үнэлэх;

19.25.2.тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах болон иргэний гомдол, саналын дагуу хяналт тавих.

19.26.Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сан улсын хэмжээний эрүүл мэндийн байгууллагын талаархи мэдээллийн лавлагаа болох бөгөөд эрүүл мэндийн байгууллага бүр тусгай зөвшөөрлийн дугаартай байна.

19.27.Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээллийг агуулах бөгөөд жилд хоёроос доошгүй удаа шинэчилнэ.



19.28.Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.29.Хэрэгцээний үнэлгээ хийх, мэргэжлийн үйл ажиллагааны төслийг үнэлэх болон хэрэгцээний тодорхойлолт гаргах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам, орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хэрэгцээний тодорхойлолт болон тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

14/25 дугаар зүйлийн 25.3.3 дахь заалт:

“25.3.3.бага эмчид эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар;”

15/25 дугаар зүйлийн 25.3.7 дахь заалт:

“25.3.7.сэргээн засах чиглэлийн мэргэжилтэнд сэргээн засах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар.”

16/25 дугаар зүйлийн 25.7-25.19 дэх хэсэг:

“25.7.Гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон эмчлэх, сувилах, эх барих, эм барих, сэргээн засах чиглэлийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй Монгол Улсын иргэнд тухайн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шууд олгож болно.

25.8.Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараахь шалгуурыг хангасан гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд олгоно:

25.8.1.анагаах ухааны боловсрол олгох сургууль төгссөн бөгөөд Монгол Улсын анагаах ухааны боловсролын зэрэгтэй дүйцэх анагаах ухааны боловсрол эзэмшсэн;

25.8.2.эх орондоо мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй буюу түүнтэй адилтгах баримт бичигтэй;

25.8.3.төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр суралцсан, төрөлжсөн мэргэшлээр тав ба түүнээс дээш жил ажилласныг нотлох хүчин төгөлдөр баримт бичигтэй;



25.8.4.Монгол Улсын аль нэг эрүүл мэндийн байгууллагад ажиллах гэрээ, хэлэлцээртэй.

25.9.Энэ хуулийн 25.8-д заасан гадаадын иргэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жил хүртэлх хугацаагаар доор дурдсан нөхцөлөөр олгоно:

25.9.1.зургаан сар хүртэлх зөвшөөрлийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтгүйгээр зөвхөн нэг удаа;

25.9.2.зургаан сараас дээш хугацааны зөвшөөрлийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн тохиолдолд.

25.10.Энэ хуулийн 25.9-д заасан зөвшөөрөлтэй гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Монгол Улсын нутаг дэвсгэрт мэргэжлийн үйл ажиллагаагаа монгол хэл дээр, шаардлагатай тохиолдолд орчуулгатай явуулна.

25.11.Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалт нь мэргэшүүлэх болон тасралтгүй гэсэн төрөлтэй байх бөгөөд төгсөлтийн дараахь мэргэшүүлэх сургалтад үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалт хамаарна.

25.12.Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн болон төгсөлтийн дараахь сургалттай холбогдсон үйл ажиллагааны удирдлагыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

25.13.Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон төрийн байгууллага нь эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, нөхөн олгох, хүчингүй болгох болон төгсөлтийн дараахь сургалт, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд мэргэжлийн нийгэмлэг, холбооны оролцоог хангана.

25.14.Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэргэшлийн зэрэг олгох болон төгсөлтийн дараахь сургалтын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөл ажиллана.

25.15.Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, эмнэлгийн мэргэжилтэнд



мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам, гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар, холбогдох маягтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, холбогдох зардлын жишгийг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

25.16.Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтын болон мэргэшлийн зэргийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам, мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам, мэргэшлийн зэргийн болон төгсөлтийн дараахь сургалтыг төгсөгчид олгох үнэмлэх, гэрчилгээний загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төгсөлтийн дараахь сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам, зардлын жишиг, сургалтын тэтгэлэг олгох шалгуур, тэтгэлгийн хэмжээ, мэргэшлийн зэргийн шалгалтын төлбөр, зардлын жишгийг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

25.17.Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн сан нь эмнэлгийн мэргэжилтний талаархи мэдээллийн лавлагаа болох бөгөөд эмнэлгийн мэргэжилтэн бүр бүртгэлийн хувийн дугаартай байна.

25.18.Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн сан нь эмнэлгийн мэргэжилтний бүртгэлд орсон он, сар, өдөр, мэргэжил, мэргэшил, төгсөлтийн дараахь сургалтад хамрагдсан байдал, мэргэшлийн зэрэг, ажиллаж байсан болон ажиллаж байгаа байгууллага, эрхэлж байгаа албан тушаалын талаархи мэдээллийг агуулах бөгөөд жил тутам шинэчлэгдэж байна.

25.19.Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журмыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.”

17/29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсэг:

“29.9.Энэ хуулийн 29.2, 29.5-д заасан мөнгөн тэтгэмжийг олгох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

18/45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг:

“45.3.Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагад тавих



нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалтын “шатны” гэсний дараа “нэгдсэн эмнэлгээс бусад” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “харьяа” гэсний дараа “нэгдсэн эмнэлгээс бусад” гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “үзүүлэх” гэсний дараа “өрхийн” гэж, 19 дүгээр зүйлийн 19.20 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлийг” гэсний дараа “энэ хуулийн 19.2-т заасан байгууллага” гэж, 24 дүгээр зүйлийн 24.6.2 дахь заалтын “эмнэлгийн” гэсний дараа “зарим” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “гэсэн төрөлтэй байна” гэсний өмнө “, сэргээн засах” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт:

“3.1.5.“эмнэлгийн мэргэжилтэн” гэж анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежийг төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хүний их, бага эмч, шүдний их эмч, уламжлалт анагаах ухааны их эмч, сувилагч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтэн;”

2/8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт:

“8.1.3.төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн болон тусгай эмнэлэг, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажилладаг бусад төрийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;”

3/8 дугаар зүйлийн 8.1.15 дахь заалт:

“8.1.15.эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг тодорхойлох, түншлэл, концессын төсөл, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эрүүл мэндийн асуудлаар хувийн хэвшил, төрийн бус байгууллага болон гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;”

4/13 дугаар зүйлийн 13.4-13.6 дахь хэсэг:

“13.4.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь өрхийн эрүүл мэндийн, эмнэлгийн мэргэшсэн, эх барихын, эмнэлгийн яаралтай, сувилахуйн дагнасан, түргэн тусламжийн, сэргээн засахын гэсэн төрөлтэй байна.

13.5.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь анхан болон лавлагаа шатлалтай байна.

13.6.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл болон түүнтэй холбогдох харилцааг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.”

5/15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт:

“15.1.3.хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв;”

6/15 дугаар зүйлийн 15.1.10, 15.1.11 дэх заалт:

“15.1.10.сэргээн засах төв;
15.1.11.тусгай эмнэлэг;”

7/16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг:

“16.1.Энэ хуулийн 15.1.1, 15.1.2, 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.8, 15.1.9, 15.1.10, 15.1.11, 15.1.13, 15.1.14-т заасан байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу зохион байгуулна.”

8/16 дугаар зүйлийн 16.3-16.8 дахь хэсэг:

“16.3.Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.4.Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийн хүн амд өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбартай байж болно.

16.5.Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл, бусад сумын хүн амыг хамруулан тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах асуудлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

16.6.Хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв нь хорт хавдрын болон бусад өвчний төгсгөлийн шатанд орсон өвчтөнд хөнгөвчлөх эмчилгээ, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.

16.7.Клиник нь үндсэн, эсхүл төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулатороор болон өдрийн эмчилгээ, үйлчилгээний хэлбэрээр үзүүлэх байгууллага байна.



16.8.Амаржих газар нь хүн амд эх барихын тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.”

9/16 дугаар зүйлийн 16.10-16.15 дахь хэсэг:

“16.10.Нэгдсэн эмнэлэг нь долоогоос доошгүй үндсэн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амбулатороор болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна.

16.11.Сувилал нь чанар, нөөц нь тогтоогдсон рашаан, байгалийн бусад хүчин зүйлийн орд газрыг ашиглан сэргээн засах болон уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна.

16.12.Түргэн тусламжийн төв нь түргэн тусламжийн үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.

16.13.Сэргээн засах төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон бусад эмнэлгээс илгээсэн өвчтөнд амбулатороор үйлчлэх, хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.

16.14.Тусгай эмнэлэг нь батлан хамгаалах, хууль сахиулах албаны албан хаагч, ял эдэлж байгаа ялтан, гэмт хэрэгт холбогдуулан шалгагдаж түр саатуулагдсан иргэнд эмнэлгийн анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.

16.15.Тусгай мэргэжлийн төв нь улсын хэмжээнд үндсэн, эсхүл төрөлжсөн нэг мэргэшлээр лавлагаа тусламж, үйлчилгээг амбулатороор үзүүлж, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх бөгөөд эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.”

10/17 дугаар зүйл:

“17 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт

17.1.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн өмчтэй холбогдох харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хүний нөөцтэй холбогдох харилцааг энэ хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.



17.2.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргана.

17.3.Хувийн хэвшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг байгуулахтай холбоотой харилцааг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

17.4.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

17.5.Энэ хуулийн 15.1.2, 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.6, 15.1.8, 15.1.9, 15.1.10, 15.1.14-т заасан орон нутгийн өмчит байгууллагын удирдлагыг энэ хуулийн 11.1.9, 12.2-т заасны дагуу томилж, чөлөөлнө.

17.6.Энэ хуулийн 17.4, 17.5-д зааснаас бусад байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлыг холбогдох бусад хуулиар зохицуулна.

17.7.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүнтэй байна.”

11/19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсэг:

“19.1.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хэрэгцээний тодорхойлолт бүхий зориулалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөцийн зохих шаардлага хангасан өмчийн аль ч хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ олгоно.

19.2.Улсын хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн бусад байгууллагад аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага” гэх/ олгоно.”

12/19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг:

“19.4.Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг гурван жилийн хугацаагаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.”



13/19 дүгээр зүйлийн 19.6, 19.7 дахь хэсэг:

“19.6.Тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллага нь хэрэгцээний үнэлгээ хийлгэх тухай хүсэлтээ мэргэжлийн үйл ажиллагааны төслийн хамт тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад хүргүүлэх бөгөөд төсөлд тухайн байгууллагын болон тусламж, үйлчилгээний төрөл, төлөвлөсөн байршил, барилга байгууламжийн талбайн төлөвлөлт, хүний нөөцийн бүрэлдэхүүн, техник, технологийн хүчин чадал, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тусгасан байна.

19.7.Хэрэгцээний үнэлгээг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас сонгон шалгаруулсан мэргэжлийн нийгэмлэг, холбоо гүйцэтгэнэ.”

14/19 дүгээр зүйлийн 19.10.2-19.10.4 дэх заалт:

“19.10.2.тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас олгосон хэрэгцээний тодорхойлолт;

19.10.3.энэ хуулийн 19.6-д заасан мэргэжлийн үйл ажиллагааны төсөл;

19.10.4.эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын барилга нь мэргэжлийн үйл ажиллагааны төсөл болон батлагдсан зураг төсвийн дагуу баригдсан, зориулалтын дагуу ашиглаж болох эсэх талаар холбогдох байгууллагаас гаргасан шийдвэр;”

15/19 дүгээр зүйлийн 19.10.6 дахь заалт:

“19.10.6.эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүний жагсаалт, мэргэжилтний бүртгэлийн дугаар, хөдөлмөрийн харилцаа үүсгэхийг зөвшөөрсөн зөвшөөрөл.”

16/19 дүгээр зүйлийн 19.11 дэх хэсэг:

“19.11.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 19.10-т заасан хүсэлт гаргагчийн баримт бичгийг хүлээн авч, өргөдлийг хянан үзэх орон тооны бус шинжээчийн баг томилон ажиллуулна.”

17/19 дүгээр зүйлийн 19.13 дахь хэсэг:

“19.13.Энэ хуулийн 19.2-т заасан байгууллага нь үүсгэн байгуулагчийн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.”

18/19 дүгээр зүйлийн 19.17.1, 19.17.2 дахь заалт:



“19.17.1.тусгай зөвшөөрөл олгосон хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагаанд явцын хяналт, шалгалт хийсэн эрх бүхий мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт;

19.17.2.тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын энэ хуулийн 19.25-д заасан хяналтын дүгнэлт.”

19/19 дүгээр зүйлийн 19.21 дэх хэсэг:

“19.21.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө энэ хуулийн 19.20.3, 19.20.4, 19.20.5, 19.20.6, 19.20.7-д заасан нөхцөл байдлыг арилгах талаар урьдчилан мэдэгдэж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаагаар түр түдгэлзүүлнэ.”

20/22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг:

“22.4.Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам, магадлан шинжлэх шалгуурыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

21/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:

“24.2.Улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх болон хяналт тавих журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

22/24 дүгээр зүйлийн 24.6.1 дэх заалт:

“24.6.1.жирэмсэн, төрөлт, төрсний дараахь үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардал;”

23/25 дугаар зүйл:

“25 дугаар зүйл.Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, төгсөлтийн дараахь сургалт, мэргэшлийн зэрэг”

24/25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг:



“25.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн үзүүлэх бөгөөд зөвхөн зөвшөөрөл олгосон төрлөөр тусламж, үйлчилгээ үзүүлнэ.”

25/25 дугаар зүйлийн 25.3.1, 25.3.2 дахь заалт:

“25.3.1.резидент эмчид эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг үндсэн мэргэшлийн сургалтын хугацаагаар;

25.3.2.үндсэн мэргэшлийн сургалтыг дүүргэсэн мэргэшсэн эмчид эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар;”

26/25 дугаар зүйлийн 25.4-25.6 дахь хэсэг:

“25.4.Энэ хуулийн 25.3.1-д заасан резидент эмч нь төгсөлтийн дараахь сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон нэгдсэн эмнэлэгт үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдах хугацаандаа хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.

25.5.Энэ хуулийн 25.3.1-д зааснаас бусад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг жил тутам тасралтгүй сургалтад хамрагдаж, багц цагаа бүрдүүлэн ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд таван жилийн хугацаагаар сунгана.

25.6.Гадаад улсад анагаах ухааны боловсрол олгох сургууль төгссөн Монгол Улсын иргэн Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуулийн 25.3-т заасны дагуу мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авна.”

27/29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг:

“29.2.Төрийн өмчийн эрүүл мэндийн болон бусад салбарын байгууллагад 25 ба түүнээс дээш жил, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтанд тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас нь тооцож олгох бөгөөд нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно.

29.3.Энэ хуулийн 29.2, 29.5-д заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоход шаардагдах зардлыг тухайн байгууллага төсөвтөө тусгасан байна.”

28/29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг:

“29.5.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно.”

29/32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэг:

“32.1.Эхийн хэвлий дэх ураг удамшлын болон бие эрхтний гаж хөгжилтэй болох нь тогтоогдсон, эсхүл тухайн жирэмслэлт эх, ургийн амь насанд ноцтой аюул учруулж болох онцгой нөхцөлд жирэмсэн эх, шаардлагатай гэж үзвэл түүний нөхөр буюу гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс бичгээр зөвшөөрөл авч, их эмч нарын хамтын шийдвэрээр жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалж болно.

32.2.Үр хөндөх ажилбарыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 14.2.2, 14.2.3-т заасан тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн эмнэлэгт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эх барих, эмэгтэйчүүдийн их эмч гүйцэтгэнэ.”

30/37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг:

“37.4.Оношилгоо, эмчилгээний зориулалтаар шинээр гарч байгаа болон био технологи, нано технологи, инновацийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд судалгаа, шинжилгээ явуулах, турших, баталгаажуулах, бүртгэх, мэдээлэх, тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг эрүүл мэндийн болон шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

31/39¹ дүгээр зүйлийн 39¹.1 дэх хэсэг:

“39¹.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн байнгын хяналтад байж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авна.”

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “15.1.10-15.1.12-т” гэснийг “15.1.12, 15.1.13-т” гэж, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн дугаарыг “16.3” гэж, 16.7-16.17 дахь хэсгийн дугаарыг “16.4, 16.5, 16.6, 16.7, 16.8, 16.9, 16.10, 16.11, 16.12, 16.13, 16.14, 16.15” гэж, 19 дүгээр зүйлийн “байгууллагад мэргэжлийн” гэснийг



“чиглэлээр” гэж, 19.3 дахь хэсгийн дугаарыг “19.10” гэж, 19.5 дахь хэсгийн дугаарыг “19.11” гэж, 19.5.2 дахь заалтын дугаарыг “19.13” гэж, 19.8 дахь хэсгийн дугаарыг “19.16” гэж, 19.9 дэх хэсгийн дугаарыг “19.17” гэж, 19.10 дахь хэсгийн дугаарыг “19.21” гэж, 19.11 дэх хэсгийн дугаарыг “19.20” гэж, 19.11.1, 19.11.2 дахь заалтын дугаарыг “19.20.1, 19.20.2” гэж, 24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх заалтын “тусламж, үйлчилгээ,” гэснийг “үйл ажиллагаа, арга хэмжээ, эмнэлгийн яаралтай болон” гэж, 24.6.8 дахь заалтын “нөхөн сэргээх” гэснийг “сэргээн засах” гэж, 25 дугаар зүйлийн 25.3.3-25.3.5 дахь заалтын дугаарыг “25.3.4, 25.3.5, 25.3.6” гэж, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “9.1.4, 9.1.8” гэснийг “8.1.18, 8.1.22” гэж, “19.10” гэснийг “19.25” гэж, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтын “эмнэлгийн” гэснийг “эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “төлбөрийн арга,” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.1, 27.3 дахь хэсгийн “их” гэсний өмнөх “хүний” гэснийг, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “9.1.3, 19.11, 31.1” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1, 13.4.2, 13.4.3, 13.4.4, 13.4.5, 13.4.6, 13.4.7 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.3, 16.5, 16.6 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.7.1, 17.7.2, 17.7.3, 17.7.4, 17.7.5, 17.7.6, 17.7.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.5.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.6.9 дэх заалт, 31 дүгээр зүйл, 39¹ дүгээр зүйлийн 39¹.2, 39¹.3, 39¹.4, 39¹.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагыг Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинэчлэн зохион байгуулна.



2 дугаар зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.21-д заасан “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшуулал, зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг эмнэлгийн төсвөөс санхүүжүүлнэ.” гэснийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.

3 дугаар зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх төлбөрийн аргыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд хуулийг дагаж мөрдөх хүртэлх хугацаанд сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг одоогийн мөрдөж байгаа аргачлалын дагуу тооцно.

4 дүгээр зүйл.2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5-д заасан “аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн болон эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно.” гэснийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд хуулийг дагаж мөрдөх хүртэлх хугацаанд аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн болон эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгоно.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ
ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон үйлдэл, эс үйлдэхүйд 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө үйлчилж байсан Эрүүгийн хуулиар ял шийтгүүлсэн этгээдийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлнө.

2 дугаар зүйл.2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон, 2016 оны 09 дүгээр сарын



01-ний өдрөөс өмнө үйлдсэн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд байгаа эрүүгийн хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хэрэгсэхгүй болгоно.

3 дугаар зүйл.2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд оногдуулсан ял нь 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэг, заалтад зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал уг ялыг шүүх дүйцүүлэн хасна.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1, 2 дугаар зүйлд заасан ажиллагааг 2016 оны 12 дугаар сарын 01-ний дотор, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан ажиллагааг 2016 оны 10 дугаар сарын 01-ний дотор багтаан хэрэгжүүлнэ.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг:

	Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харьяалал
Нэг.Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх			
1	Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж



5	Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
12	Завхан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
15	Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
17	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж



19	Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
20	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
22	Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
23	Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
24	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
25	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

2/2 дугаар зүйлийн нэг, хоёр дахь хэсэг:

	Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харьяалал
Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх			
1	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх дүүрэг
2	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг
3	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг
4	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол дүүрэг
5	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Хан-Уул дүүрэг



6	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг
7	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багануур дүүрэг
8	Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багахангай, Налайх дүүрэг
Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх			
1	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх дүүрэг
2	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг
3	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг
4	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол дүүрэг
5	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Хан-Уул дүүрэг
6	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг
7	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багануур дүүрэг
8	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багахангай, Налайх дүүрэг

2 дугаар зүйл. Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсэг:

“12.7. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхэд томилолтоор ажиллаж болно. Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.”

2/21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалт:

“21.1.4. тухайн шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцох;”

2 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “зөвлөлийн,” гэсний дараа “Улсын дээд шүүхийн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүх

19.1. Давж заалдах шатны шүүхийн тогтолцоо нь дараахь бүтэцтэй байна:

- 19.1.1. аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх;
- 19.1.2. аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх;
- 19.1.3. аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх;
- 19.1.4. нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх;
- 19.1.5. нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх;



19.1.6.захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх.

19.2.Аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нь шүүн таслах ажлын төрлөөр хэрэг маргааныг хянан шийдвэрлэх эрүү, иргэний хэргийн танхимтай байна.

19.3.Давж заалдах шатны шүүхийн шүүгч энэ хуулийн 19.2-т заасан танхимын аль нэгэнд харьяалагдах бөгөөд өөр танхимын шүүн таслах ажиллагаанд оролцохыг хориглоно.”

4 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн гарчгийн “Танхимын” гэснийг “Улсын дээд шүүхийн танхимын” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалтын дугаарыг “21.1.5” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 78.6 дахь хэсэг нэмсүгэй:

“78.6.Тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар өөр шүүхийн шүүгчийг томилж, оролцуулна.”

2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсгийн “, эсхүл шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй” гэснийг хассугай.



3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 223 дугаар зүйлийн 223.3 дахь хэсгийн "дээд шатны шүүхийн" гэснийг "адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж, тухайн шүүхийн" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 72.6 дахь хэсэг нэмсүгэй:

"72.6.Тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар өөр шүүхийн шүүгчийг бүрэлдэхүүнд томилж, оролцуулна."

2 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийн " , шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй болсон" гэснийг хассугай.



3 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болмогц анхан болон давж заалдах шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа эрүү, иргэний хэрэг, маргааныг Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд заасан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхэд шилжүүлнэ.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

**Шүүгчийн орон тоог шинэчлэн
батлах тухай**

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн орон тоог 1 дүгээр хавсралтаар, анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоог 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол баталсантай холбогдуулан “Шүүгчийн орон тоо батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 59 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



3.Энэ тогтоолыг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2016 оны
42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ОРОН ТОО**

Д/д	Шүүхийн нэр	Шүүгчийн орон тоо	
		Ерөнхий шүүгч	Шүүгч
Нэг.Аймаг, нийслэлийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн орон тоо:			
1.	Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
2	Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
3.	Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
4.	Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
5.	Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
6.	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
7.	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	3
8.	Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	3
9.	Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
10.	Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
11.	Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
12.	Завхан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
13.	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	3



14.	Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	3
15.	Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
16.	Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
17.	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
18.	Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
19.	Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
20.	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
21.	Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
22.	Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
23.	Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
24.	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	15
25.	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	15
	Нийт	25	118
Хоёр.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн орон тоо:			
1.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	1	15
	Нийт	1	15

Монгол Улсын Их Хурлын 2016 оны
42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН
ОРОН ТОО**

Д/д	Шүүхийн нэр	Шүүгчийн орон тоо	
		Ерөнхий шүүгч	Шүүгч
Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо:			
1.	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	16
2.	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	13



3.	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	11
4.	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	15
5.	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	10
6.	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	13
7.	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
8.	Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
Нийт		8	88
Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо:			
1.	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	14
2.	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	9
3.	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	9
4.	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	11
5.	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	7
6.	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	14
7.	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5
8.	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5
Нийт		8	74
Гурав.Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо:			
1.	Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
2.	Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
3.	Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
4.	Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
5.	Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
6.	Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
7.	Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
8.	Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3



9.	Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
10.	Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
11.	Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
12.	Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
13.	Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
14.	Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
15.	Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
16.	Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
17.	Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
18.	Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
19.	Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
20.	Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
21.	Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
22.	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	19
	Нийт	22	82
Дөрөв.Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо:			
1.	Архангай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
2.	Баян-Өлгий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
3.	Баянхонгор аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
4.	Булган аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
5.	Говь-Алтай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
6.	Говьсүмбэр аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	3
7.	Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	6
8.	Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4



9.	Дорнод аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
10.	Дундговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
11.	Завхан аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
12.	Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	6
13.	Өмнөговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
14.	Өвөрхангай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
15.	Сүхбаатар аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
16.	Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
17.	Төв аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
18.	Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
19.	Ховд аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
20.	Хөвсгөл аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
21.	Хэнтий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
	Нийт	21	99
Тав.Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо:			
1.	Архангай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
2.	Баян-Өлгий аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
3.	Баянхонгор аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
4.	Булган аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
5.	Говь-Алтай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
6.	Говьсүмбэр аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
7.	Дархан-Уул аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5



8.	Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
9.	Дорнод аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	4
10.	Дундговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
11.	Завхан аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
12.	Орхон аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5
13.	Өмнөговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
14.	Өвөрхангай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
15.	Сүхбаатар аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
16.	Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
17.	Төв аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5
18.	Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
19.	Ховд аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
20.	Хөвсгөл аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5
21.	Хэнтий аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
	Нийт	21	72
Зургаа.Сум дундын шүүхийн шүүгчийн орон тоо			
1.	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүх	1	4
2.	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын шүүх	1	4
3.	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын шүүх	1	3
4.	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүх	1	4
5.	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүх	1	4
6.	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүх	1	4
7.	Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүх	1	4
8.	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүх	1	4
	Нийт	8	31



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар
хот

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2014 оны 53 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл /цаашид “Үндсэн чиглэл” гэх/-ийн биелэлтийг Улсын Их Хурлаар хэлэлцсэнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэгт/-т даалгасугай:

1/Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсан дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгааныг тодорхой болгож, хэрэгцээ, шаардлага, хөрөнгийн эх үүсвэрийг харгалзан эрэмбэлж, хэрэгжүүлэх боломжтой зорилт, арга хэмжээг 2016 оны Үндсэн чиглэлтэй хамтатган хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

2/Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн төлөвлөлт болон санхүүжилтийн бусад эх үүсвэртэй уялдуулж, тухайн жилд хэрэгжих боломж, бодит байдлыг харгалзан зорилт, арга хэмжээ бүрийн хүрэх түвшин, түүний биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, үргэлжлүүлэн санхүүжүүлэх зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг дараа жилийн Төсвийн тухай хуульд нэмж тусгаж байх;

3/Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад тавих дотоодын байнгын хяналтыг сайжруулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдөх;

4/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын 2015 оны 52 дугаар тогтоол, эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах.



2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/, Төрийн байгуулалтын байнгын хороо /А.Бакей/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

**“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын
байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний
тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоолын 1, 2 дахь заалтын 1, 2 дахь дэд заалтын “хоршооны гишүүн” гэснийг тус тус хассугай.

2.Энэ тогтоол баталсантай холбогдуулан “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоолын 4 дэх заалт болон “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 73 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

**“Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг
дэмжих зарим арга хэмжээний тухай”
тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн



74 дүгээр тогтоолын 2 дахь заалтын 1, 2, 3 дахь дэд заалтын “хоршооны гишүүн” гэснийг хассугай.

2.Энэ тогтоол баталсантай холбогдуулан “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 74 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар
хот

Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

1/Дорнод аймгийн Халх гол сумын нутагт Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах;

2/Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн хэмжээ, хилийн зааг, мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагаа, тариалангийн технологи болон холбогдох бусад журмыг тогтоож, харьяалах төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэх.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Хөдөө аж ахуйн “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 75 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлах санал хураалтад оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39^{1.2} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ганхуягийн Шийлэгдамбыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэнд, спортын сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2016 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэнд, спортын сайдаар Самбуугийн Ламбааг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 18.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул Ванчигдоогийн Жавхланг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Тогтохдоржийн Долгорсүрэнг Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас, шүүгчийн албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан тул Чойжилын Оюунгэрэлийг Сүхбаатар аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4

Индекс: 14003